

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН
Я.ШАРАВДОРЖИЙН НЭРЭМЖИТ ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/23

Мөрөн

Арга хэмжээ авах тухай

Монгол улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 131 дүгээр зүйлийн 131.1.2, “Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний технологийн сахилгын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.б, 4.3.а, Салбарын хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлийн 5.1.2.1, 5.1.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цагаан-Үүр цаг уурын өртөөний техникч Эрдэнэсан овогтой Батсүх, Чимэдцэрэн овогтой Чимгээ, Мөнхсайхан овогтой Мягмарсүрэн нар 2017 оны 06 дугаар сарын хөтөлбөрт шинжилгээний ажлын ажиглалтын чанар муу, технологийн сахилгын зөрчил гаргасан тул үндсэн цалинг 1 сарын турш 20%-иар бууруулах арга хэмжээг авсугай.

2. Дээрх нэр бүхий техникчдийн үндсэн цалинг 2017 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн 1 сарын турш 20%-иар бууруулан олгохыг нягтлан бодогч /Н.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

3. Цагаан-Үүр өртөөний техникчдийн ажилд дахин технологийн зөрчил гаргуулахгүй байхад хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч ажиллахыг Цагаан-Үүр цаг уурын өртөөний дарга Л.Тунгалаг, цаг уурын технологич инженер Э.Баяржаргал, ХААЦУ-ын технологич инженер Л.Байгальмаа, ЦУОТХ-ийн дарга Б.Өнөрбат нарт тус тус үүрэг болгосугай.

4. Цаашид нийт ажилтан, албан хаагчдыг хөтөлбөрт шинжилгээний ажлын үр дүнг сайжруулан, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний технологийн сахилгын дүрмийг баримтлан ажилдаа хариуцлагатай хандаж ажиллахыг анхааруулсугай.

ДАРГА



А.ҮНЭНБАЯР